

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ОЮУТНЫ СОЁЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА

ШИНЭ ОЮУТАНД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2022 он

АМЖИЛТТАЙ СУРАЛЦАХ 10 ЗӨВЛӨГӨӨ

1. Өөрийнхөө хүчинд итгэлтэй бай. Суралцах хүсэл эрмэлзлэлтэй байж, мэдлэг эзэмших сонирхлоо хөгжүүлж ажилла. Өөрийнхөө хүчинд итгэхгүй байх шиг тийм гутамшиг гэж үгүй.
2. Сайн хөдөлмөрлөж, хөдөлмөрийг хайрлаж сур. Зохион бүтээгч Эдисоний “Шинжлэх ухаанд бүх зүйлийн 1%-ийг авъяасаар, 99%-ийг хичээл зүтгэлээр бий болгодог” гэсэн үгийг санаж яв.
3. Анхаарлаа төвлөрүүл. Анхаарлаа ганц мөч л өөр зүйлд хандуулахад цааш суралцахад онц чухал зүйлийг өнгөрөөж, суралцах чадваргүй болоход хүрч болно. Хэрэв нэг л зүйлийг анхааралгүй орхигдуулбал түүнийгээ маргааш гэлгүй тэр дор нь мэдэж авч бай.
4. Суралцах тодорхой дэг журмыг баримталж, ажил амралтаа зохицуулж бай. Хүнд хөнгөн хичээлийн даалгаврыг сэлгүүлэн зохицуулсан өдрийн цагийн хуваарийг сайн бодож боловсруулан мөрдөж ажилла.
5. Бүх зүйлийг цээжлэх гэж бүү оролд. Ой тогтоолтондоо найдахын зэрэгцээ бие дааж сэтгэж сур. Сэтгэж ойлгосноор үзэгдэл юмсын учир шалтгаан, холбоог таниж мэднэ. Аль болохоор яагаад гэсэн асуултыг өөртөө болон бусдад тавьж байх нь зүйтэй.
6. Дүрслэн мэдрэх гэсэн чухал мэдрэмжээ ашиглаж сур. Уншиж буй зүйлээ болон багшийн яриаг сонож байх үедээ судалж байгаа зүйлийг амьд тодоор дүрслэн сэтгэхийг аль болохоор хичээж бай. “Хүний үүрэг зөвхөн мэдлэгээр дүүргэх бус харин гал ноцоох оч байх ёстой” гэсэн үгийг санагтун.
7. Бие дааж суралцах чадвартай болох хэрэгтэй. Багш л толгойд хийгээд өгчихнө гэж хүлээж болохгүй.
8. Гэрийн номын сандаа хичээлийн хуваарь, цагийн хуваарь, ажлын схем, шаардагдах ном, сурах бичиг зэрэг өөрт хэрэгтэй гэсэн зүйлүүдээ аль болох өөртөө ойр, олоход буюу авахад хялбар тавьсан байх хэрэгтэй.
9. Өөртөө олж авсан мэдлэгийг хаана яаж хэрэглэхийг тогтмол эрж хайж бай. Бодлого их бод, Зохиож бай. Зөвхөн толгойгоороо биш гараараа ч бас ажилла.
10. Даалгавраа аль болохоор бага цагт их хүч энерги зарцуулж хийхийг эрмэлз. Бодлого бодох бэлтгэлд бэлтгэх, зохион бичлэг хийхэд урлаг шаардагдана. Түүнийг эзэмш.

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ

ШУТИС-ийн танилцуулга, сургалтын үйл ажиллагаа.	4
2022-2023 оны хичээлийн жил оюутны үйлчилгээний нэгдсэн хуанли.	10
Оюутны тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг.	21
Гадаад, дотоод тэтгэлэг, хөтөлбөрт хамрагдах.	22
Замын зардлын нөхөн олголт.	24
Оюутан танд шаардлагатай дүрэм журам.	24
Оюутан дэмжих үйлчилгээ.	26
Зөвлөмж.	30

ӨМНӨХ ҮГ

Монгол улсад төдийгүй дэлхий дахинд дээд боловсролын шинэчлэл улмаар цахим сургалт эрчимтэй өрнөж байна.

ШУТИС-ийн оюутан та бүхэнд бие даан амжилттай суралцах, орон зай цаг хугацаанаас үл хамааран шаардлагатай мэдээллийг авч өөрийгөө хөгжүүлэх цахим гарын авлагыг хүргэж байна.

Энэхүү гарын авлагад ШУТИС-ийн сургалтын үйл ажилагаа, Оюутны соёл, үйлчилгээний алба, Шинжлэх ухаан технологийн төв номын сан, Эрүүл мэнд, спорт сургалтын төв, Оюутны холбоо, Оюутны зөвлөл, Оюутны клубүүдийн үйл ажиллагаа болон бусад оюутанд үзүүлэх нийгэм хүмүүнлэгийн үйл ажиллагаа, дүрэм журам, зөвлөгөө, зөвлөмж зэргийг тусгасан болно.

Энэ цаг үед мэдээллийг цахим хэлбэрээр хүлээн авдаг болсон хэдий ч бидний ажлын арга туршлагаас харахад шинэ элсэгч оюутнууд хаанаас ямар мэдээлэл авах, цаг хугацаа нь хэдийд вэ гэдэг асуулгад хариулах гарын авлага зайлшгүй шаардлагатай байна.

Оюутан та эдгээр мэдээ мэдээллийг өөрийн сурах, хөгжих үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэн, гарын авлагыг зөвлөгч, чиглүүлэгчээ болгон ашиглана гэдэгт ШУТИС-ийн удирдлага, профессор, эрдэмтэн багш нар бүрэн итгэлтэй байна.

НОМЫН ЦАГААН БУЯН ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ.

ШУТИС-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Оюутан та бүхний өмнө ажил, амьдралд бэлтгэх нэн хариуцлагатай цаг үе ирсэн байна. Энэ нь “ШУТИС-ийн оюутан” хэмээх нэрийг өндөрт өргөн манлайлан суралцах нэр хүндтэй үүрэг, хариуцлагаа ухамсартайгаар биелүүлж гүйцэтгэхэд оршино.

Та элссэн сургуульдаа амжилттай суралцах зорилго тавьж, төлөвлөсөн хугацаандаа төгсөх улмаар давхар мэргэжил болон хос мэргэжил эзэмших нь зөвхөн оюутан таниас хамаарна.

Иймд та зөвхөн их сургуульд сурна, хөгжинө, чадна гэдэг эрхэм зорилгоо л өмнөө тавь. Зорилгоо биелүүлэхийн тулд та:

1. Сургуулийн дүрэм журам, үйл ажиллагаатай сайтар танилцах
2. Сургалттай холбоотой төлбөр тооцоо, хичээл сонголт, сургалтын төлөвлөгөө, сургалтын болон оюутны үйлчилгээний нэгдсэн хуанли, зөвлөх багштайгаа уулзаж байнга мэдээлэл авах хэрэгтэй. Оюутан танд зөвлөх багш мэдээлэл түгээх, чиглүүлэх үүргийг л гүйцэтгэнэ. Зөвлөх багштайгаа аль болох ойр байж, таны дотны туслагч гэдгийг бүү март.
3. Сургуулийн талаарх мэдээллийг must.edu.mn сайт, холбогдох facebook зэргээс өөртөө тогтмол мэдээлэл авч сурах

Танд ШУТИС-ийн бүтэц бүрэлдэхүүний талаар танилцуулья: ШУТИС нь нийт 10 бүрэлдэхүүн, ахисан түвшний 2 сургууль, орон нутгийн 2 сургууль, МСҮТ-2, ахлах сургууль, Коосен технологийн коллежтой, (сургуулиудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох сайтаас авч болно. <http://must.edu.mn>)

ШУТИС-д элссэн оюутан залуус та бүхэнд баяр хүргэе.

ШУТИС-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Оюутан та бүхний өмнө ажил, амьдралд бэлтгэх нэн хариуцлагатай цаг үе ирсэн байна. Энэ нь “ШУТИС-ийн оюутан” хэмээх нэрийг өндөрт өргөн манлайлан суралцах нэр хүндтэй үүрэг, хариуцлагаа ухамсартайгаар биелүүлж гүйцэтгэхэд оршино.

Та элссэн сургуульдаа амжилттай суралцах зорилго тавьж, төлөвлөсөн хугацаандаа төгсөх улмаар давхар мэргэжил болон хос мэргэжил эзэмших нь зөвхөн оюутан таниас хамаарна.

Иймд та зөвхөн их сургуульд сурна, хөгжинө, чадна гэдэг эрхэм зорилгоо л өмнөө тавь. Зорилгоо биелүүлэхийн тулд та:

4. Сургуулийн дүрэм журам, үйл ажиллагаатай сайтар танилцах
5. Сургалттай холбоотой төлбөр тооцоо, хичээл сонголт, сургалтын төлөвлөгөө, сургалтын болон оюутны үйлчилгээний нэгдсэн хуанли, зөвлөх багштайгаа уулзаж байнга мэдээлэл авах хэрэгтэй. Оюутан танд зөвлөх багш мэдээлэл түгээх, чиглүүлэх үүргийг л гүйцэтгэнэ. Зөвлөх багштайгаа аль болох ойр байж, таны дотны туслагч гэдгийг бүү март.
6. Сургуулийн талаарх мэдээллийг must.edu.mn сайт, холбогдох facebook зэргээс өөртөө тогтмол мэдээлэл авч сурах

Танд ШУТИС-ийн бүтэц бүрэлдэхүүний талаар танилцуулья: ШУТИС нь нийт 10 бүрэлдэхүүн, ахисан түвшний 2 сургууль, орон нутгийн 2 сургууль, МСҮТ-2, ахлах сургууль, Коосен технологийн коллежтой, (сургуулиудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох сайтаас авч болно. <http://must.edu.mn>)

ШУТИС-д элссэн оюутан залуус та бүхэнд баяр хүргэе.

ШУТИС-ийн танилцуулга

Улаанбаатар хотод

1. Барилга, архитектурын сургууль
<http://www.scea.edu.mn/>
2. Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
<http://www.csms.edu.mn>
3. Үйлдвэрлэлийн технологийн сургууль
<http://www.sfeb.edu.mn/>
4. Геологи, уул уурхайн сургууль
<http://www.gs.edu.mn>
5. Мэдээлэл, холбооны технологийн сургууль
<http://www.sict.edu.mn>
6. Эрчим хүчний сургууль
<http://www.pes.edu.mn>
7. Механик тээврийн сургууль
<http://www.mes.edu.mn/>
8. Хэрэглээний шинжлэх ухааны сургууль
<http://www.ms.edu.mn>
9. Гадаад хэлний сургууль
<http://www.fli.edu.mn>
10. Бизнесийн ахисан түвшний сургууль
<http://bzgrad.edu.mn/mn/>
11. Инженерийн ахисан түвшний сургууль

Дархан уул аймаг дахь технологийн сургууль

<http://www.stda.edu.mn>

Ш.Отгонбилэгийн нэрэмжит “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль

<http://erdenetis.edu.mn/>

Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль

ШУТИС-ийн харъяа ерөнхий боловсролын ахлах сургууль

<http://www.musthighschool.mn/>

ШУТИС-КООСЭН технологийн коллеж

<http://kosentc.edu.mn/mn/>

ШУТИС нь Хичээлийн найман байртай бөгөөд

Хичээлийн I байранд ҮТС, ХШУС

Хичээлийн II байранд БАС, ГУУС, ЭХС

Хичээлийн IV байранд ҮТС, Ахлах сургууль

Хичээлийн V байранд БуХС

Хичээлийн VI байранд МХТС

Хичээлийн VII байранд МТС

Хичээлийн VIII байранд Коосен технологийн коллеж, лаборатори, музей,

FM зэрэг тус тус байрладаг

Оюутны мэдлэгийн үнэлгээ

Оюутны мэдлэгийн үнэлгээний систем нь хоёр үе шаттай.

Тухайн хичээлийн үнэлгээ. Уг хичээлээр оюутан эзэмшвэл зохих мэдлэгийг олж авахын тулд улирлын турш хэрхэн сурч хөдөлмөрлөснөө, тухайн хичээлийг заасан багшаар 70 хүртэл оноогоор, жинхэнэ мэдлэгийн түвшинг улирлын шалгалтын 30 хүртэл оноогоор тус тус заавал үнэлүүлнэ. Багшийн үнэлгээний

70 оноо нь дөрвөн улирлын хугацаанд хүчинтэй байна. Эдгээрийн нийлбэрийн 100 хүртэл оноог лавлах хүснэгтийг ашиглан үсгэн үнэлгээнд шилжүүлнэ.

ОНОО	ҮСГЭН ҮНЭЛГЭЭ	ҮНЭЛГЭЭНИЙ ОНОО
96-100	A	4.0
91-95	A-	3.7
88-90	B+	3.4
84-87	B	3.0
81-83	B-	2.7
78-80	C+	2.4
74-77	C	2.0
71-73	C-	1.7
68-70	D+	1.3
64-67	D	1.0
61-63	D-	0.7
0-60	F	0.0
A,A-,B+,B,B-,C+	CR	0.0

Үнэлгээний голч дүн (GPA). Үнэлгээний голч дүнг тооцохдоо, хичээл бүрийн үсгэн үнэлгээг оноонд шилжүүлэн, улмаар тухайн хичээлийн харгалзах кредитээр үржүүлж, дундажлах замаар тодорхойлно. Оюутан бүрээр улирал бүрийн эцэст тухайн улиралд дүгнэгдсэн хичээлүүдийн хувьд

бодогддог **Улирлын Үнэлгээний Голч Дүн** ба оюутны нийт суралцсан хугацаандаа дүгнэгдсэн хичээлүүдийн хувьд бодогддог **Хуримтлуулсан Үнэлгээний Голч Дүн** гэсэн ерөнхий нэг аргачлалтай хоёр тоон утгыг тооцоолж гаргасны эцэст оюутны дүнгийн хуудсыг хэвлэж, хувийн хэрэгт хийнэ.

Оюутны тухайн хичээлээр авч болох тэмдэглэгээ

Тухайн улирлын эцэст оюутан бүрээр бодогддог улирлын үнэлгээний голч дүнг тооцож гаргахад дараах тэмдэглэгээнүүд хэрэглэгдэнэ. Үүнд:

U - Оюутан кредит шууд тооцох шалгалт өгөх

E - Улирлын шалгалт өгөөгүй

R - Тухайн хичээлд дахин суралцахаар шийдсэн

W - Хичээлийн явцад суралцахаас татгалзаж хаясан

R, W тэмдэглэгээнд харгалзах үнэлгээний оноо 0.0 байна.

Оюутан нь дээрх тэмдэглэгээтэйгээр шалгагдсан тухайн хичээлийг дахин судалж, “A-F” үнэлгээтэйгээр шалгуулах үүрэгтэй.

Оюутан кредит шууд тооцох шалгалт өгөх “U” Uncomplete

Оюутан тухайн хичээлийг өөрийн мэдлэг, дадлага, чадварыг хангалттай гэж үзвэл кредит шууд тооцох 30 хүртэл онооны шалгалтанд өөрийн хүсэлтээр орж болно. (Сургалтын системийн талаар дэлгэрүүлж must.edu.mn/beta3/menu136 үзнэ үү.)

Их сургуулиас оюутны сургалт, хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах Сургалтын нэгдсэн хуанли <https://www.must.edu.mn/mn/page/209> дэлгэрүүлэн судлах, Оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлиг жил бүр боловсруулан гаргадаг. Эдгээр хуанли нь та бүхний сурах үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаас гадна оюутны хувь хүнийг хөгжүүлэх үйл ажиллагаанд чиглүүлэх зорилготой.

ШУТИС-ийн Оюутны соёл, үйлчилгээний алба нь оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлиг боловсруулахдаа оюутны хувь хүний хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг элсэгч, суралцагч, төгсөгч гэсэн системтэй хөтөлбөр төлөвлөгөөний дагуу явуулах цаг хугацааг нарийвчлан гаргаж өгдөг.

1. Шинэ оюутанд чиглэсэн үйл ажиллагаа:

ШУТИС-д шинээр элссэн оюутан та өөрийн хүссэн, сонгосон мэргэжлээрээ суралцах боллоо. Танд одоо хичээл сонголтоо бие даан хийж суралцах, бие даан амьдарч суралцах шаардлага урган гарч ирнэ. Энэ цаг үед танд олон асуудлууд тулгарч байгаа. Үүнийг та хэрхэн шийдвэрлэх вэ гэхлээр танд биднээс хүргэх ШУТИС-ийн шинэ оюутанд зориулсан “Хөгжлийн хөтөлбөр”-г хоцрохгүйгээр хамрагдах нь чухал юм. Бид тус хөтөлбөрийг цахимаар болон танхимаар тогтмол хүргэнэ.

ШУТИС-ийн шинэ оюутанд зориулсан хөгжлийн хөтөлбөр

Зорилго: Шинээр элссэн оюутны сурах үйл ажиллагааг дэмжих зорилгоор хувь хүний хөгжил, төлөвшилд чиглэсэн мэдлэг, мэдээллийг цахим болон танхимаар хичээлийн бус цагаар системтэй хүргэх.

Д/д	Хийгдэх ажил	Хариуца нзохион байгуулах	Хугацаа (Хичээлийн долоо хоног)	Хамтран ажиллах
1	Шинээр элссэн оюутанд сургалтын үйл ажиллагаа, оюутны үйлчилгээний талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх “Танд тусалъя” аян	ОСҮА	0 дугаар долоо хоног	Оюутны холбоо, клубүүдийн нэгдсэн зөвлөл
2	ШУТИС-ийн хичээлийн шинэ жилийн нээлт, өдөрлөг	ОСҮА	I долоо хоног	Бүрэлдэхүүн сургууль, оюутны клубүүд, оюутны зөвлөл
3	Бүрэлдэхүүн сургуулиудын багш, оюутны нэгдсэн уулзалт (Сургалтын систем, сургалтын төлөвлөгөө, эрдэм шинжилгээ, оюутны зөвлөл, оюутны клубийн үйл ажиллагаа, зөвлөх багшийн үүрэг роль, хичээлийн байрууд, номын сан, лаборатори, музейтэй танилцуулах)	ОСҮА	I-II долоо хоног	Бүрэлдэхүүн сургууль, ангийн (зөвлөх) багш, оюутны зөвлөлийн дарганар
4	“Амжилттай суралцах нь” лекц	ОСҮА	III долоо хоног	Бүрэлдэхүүн сургууль, зөвлөхбагш, оюутны зөвлөл

5	“Харилцаа ёс зүй” сургалт	ОСҮА	IV долоо хоног	Мэргэжлийн багш, лекторууд
6	“Хотын соёл” аяны арга хэмжээ -Хотын соёлд суралцах нь -Баруун гарын дүрэм хэрэгжүүлэх	ОСҮА	VI-VII долоо хоног	БУХС-ийн монголын түүхийн багш нар, НЦУГ, “Соёмбо” клуб
7	“Эрүүл зөв, зохистой хоололт” сургалт	ОСҮА	VII-X долоо хоног	ҮТС, “Зохистой хооллолт” клуб, Оюутны байрныэрхлэгч, оюутнызөвлөл
8	“Оюутны хөгжил, төлөвшилд багшийн оролцоо” семинар	ОСҮА	Намрын улиралд	СБЗГ, Бүрэлдэхүүн сургууль

“Хөгжлийн хөтөлбөр”- т тусгагдсан бүх үйл ажиллагаа болон бусад оюутны үйлчилгээнд чиглэсэн үйл ажиллагааг оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлид тусгав.

ОЮУТНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ХУАНЛИ / 2022-2023 оны хичээлийн жил / НАМРЫН УЛИРАЛ

8 сар, 2022

Дх					1
Д	1	8	15	22	29
М	2	9	16	23	30
Л	3	10	17	24	31
П	4	11	18	25	
Б	5	12	19	26	
Б	6	13	20	27	
Н	7	14	21	28	

08 дугаар сарын 22 - 9 дүгээр сарын 30, Даваа – Баасан

Боловсролын зээлийн санд хамрагдах хүсэлтэй оюутнуудын бүртгэл явагдана.

08 дугаар сарын 19, Баасан

2021-2022 оны хаврын улирлын кредитийн урамшууллын тушаал гарна

08 дугаар сарын 22- 31, Даваа- Лхагва

“Шинэ оюутанд туслах аян” чиглүүлэгч оюутнууд ажиллана /КНЗ¹/

08 дугаар сарын 29 - 09 дүгээр сарын 16, Даваа - Баасан

Оюутнуудын нийтийн тээврийн хөнгөлөлтийн карт захиалга явагдана.

¹ Клубүүдийн нэгдсэн зөвлөл

9 сар, 2022

Дх	I	II	III	IV	V
----	---	----	-----	----	---

Д		5	12	19	26
---	--	---	----	----	----

М		6	13	20	27
---	--	---	----	----	----

Л		7	14	21	28
---	--	---	----	----	----

П	1	8	15	22	29
---	---	---	----	----	----

Б	2	9	16	23	30
---	---	---	----	----	----

Б	3	10	17	24	
---	---	----	----	----	--

Н	4	11	18	25	
---	---	----	----	----	--

09 дүгээр сарын 01, Пүрэв

Хичээлийн шинэ жилийн нээлт

09 дүгээр сарын 01 – 10 дугаар сарын 03 Пүрэв - Даваа

Захирлын нэрэмжит тэтгэлэг – Шилдэг элсэгчдийн материал хүлээн авна.

09 дүгээр сарын 05-09, Даваа-Баасан

Шинэ элсэгчдэд сургуулийн үйл ажиллагааг танилцуулах нэгдсэн уулзалт

09 дүгээр сарын 09, Баасан

Нэгдүгээр курсийн зөвлөх багш нарын нэгдсэн сургалт, семинар

09 дүгээр сарын 12-23, Даваа-Баасан

“Амжилттай суралцах нь” лекц

09 дүгээр сарын 12-10 сарын 14, Даваа - Баасан

Оюутнууд эрүүл мэндийн даатгалын сунгалт хийлгэх

09 дүгээр сарын 21-30, Лхагва-Баасан

“Харилцааны ёс зүй, төлөвшил” сургалт

09 дүгээр сарын 19-23 Даваа – Баасан

Клубүүдийн нээлттэй өдөрлөг /КНЗ/

09 дүгээр сарын 13-24, Даваа – Баасан

ШУТТНомын сангийн нээлттэй хаалганы өдрүүд /ШУТТНС/

09 дүгээр сарын 26-30, Даваа-Баасан

“Тамхи-Бидний эрүүл мэнд” аян /ЭМСТ, ОСҮА, ЗУЗ Клуб, Соёмбо клуб/

10 сар, 2022

Дх	V	VI	VII	VIII	IX	
----	---	----	-----	------	----	--

Д		3	10	17	24	31
---	--	---	----	----	----	----

М		4	11	18	25	
---	--	---	----	----	----	--

Л		5	12	19	26	
---	--	---	----	----	----	--

П		6	13	20	27	
---	--	---	----	----	----	--

Б		7	14	21	28	
---	--	---	----	----	----	--

Б	1	8	15	22	29	
---	---	---	----	----	----	--

Н	2	9	16	23	30	
---	---	---	----	----	----	--

10 дугаар сарын 03-28, Даваа-Баасан

“Хотын соёл” аян /ОСҮА, КНЗ, БУХС-ХУС², ЦЕГ³/

10 дугаар сарын 12, Лхагва

“Зочны цаг” уулзалт лекц

10 дугаар сарын 24- 11 сарын 01 Даваа-Мягмар

ШУТИС-ийн элсэгчдийн аварга шалгаруулах тэмцээн

10 дугаар сарын 14-11 дүгээр сарын 04, Баасан – Баасан

“Эрүүл зөв хооллолт” сургалт, аян

10 дугаар сарын 13, Пүрэв

Судлаач оюутанд цуврал лекц I

10 дугаар сарын 08, 09, Бямба- Ням

“Эко боловсрол- Эрүүл мэнд” их цэвэрлэгээ /ЭМСТ, ОСҮА, ОХ, КНЗ/

10 дугаар сарын 03-07, Даваа -Баасан

“Мицибүши” корпорацийн тэтгэлэгийн материал

² БУХС-ийн Хүмүүнлэгийн Ухааны салбар

³ Цагдаагийн ерөнхий газар

хүлээн авна. \ГХХАА⁴\

10 дугаар сарын 14 Баасан

Сургалтын тэтгэлэг олгодог байгууллагуудын өдөрлөг

10 дугаар сарын 12 -12 сарын 13, Мягмар - Мягмар

“Ажил эрхлэлтэд чиглүүлэх” модуль сургалт /Төгсөх ангийн оюутнуудад/

10 дугаар сарын 20-21, Пүрэв- Баасан

ШУТИС-ийн дэргэдэх “Хос-Уянга” хамтлагийн 20 жилийн ойн тоглолт

10 дугаар сарын 17-28, Даваа-Баасан

“Мэргэжил бүхэн сайхан” ЕБС-ийн сурагчдад мэргэжил сурталчилах аян

10 дугаар сарын 24- 11 дүгээр сарын 11, Даваа-Баасан

“Соёлын өдөрлөг” аяны арга хэмжээ (БуХС-ХУС, ОСҮА)

10 дүгээр сарын 24-28 , Даваа-Баасан

“Таны санхүүгийн мэдлэгт” лекц

10 дугаар сарын 24- 11 дүгээр сарын 28, Даваа-Даваа

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн “Урлагийн бага наадам”

10 дугаар сарын 26, Лхагва

“Зочны цаг” уулзалт лекц

11 сар, 2022

Дх	X	XI	XII	XIII	XIV
----	---	----	-----	------	-----

Д		7	14	21	28
М	1	8	15	22	29
Л	2	9	16	23	30
П	3	10	17	24	
Б	4	11	18	25	

Б	5	12	19	26	
Н	6	13	20	27	

11 дүгээр сард (Зарын дагуу)

Монгол улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгийн материал хүлээн авна.

11 дүгээр сарын 01–12, Мягмар -Баасан

ШУТИС –ийн оюутны Спортын их наадам \Оюутны холбоо, БТТ⁵\

11 дүгээр сарын 04, Баасан

Шинэ номын нээлт. Зохиогч-уншигчийн уулзалт, ярилцлага /ШУТНС/

11 дүгээр сарын 09, Лхагва

Залуу инженер – лекц \ хурлын танхим\

11 дүгээр сарын 01 – 11, Мягмар – Баасан

Төгсөгчид “Төгсөх оюутны анкет”-аа онлайнаар бүртгүүлнэ.

11 дүгээр сарын 01-14, Мягмар -Даваа

“Тоёото-ШУТИС” сангийн тэтгэлэгийн материал хүлээн авна. \ГХХАА\

11 дүгээр сарын 01-12, Мягмар -Баасан

Англи хэлний уламжлалт олимпиад /ГХС⁶, ОСҮА/

11 дүгээр сарын 11, Баасан

“Чихрийн шижинтэй тэмцэх дэлхийн өдөр” /ЭМСТ, ҮТС ШТСТ/

11 дүгээр сарын 09, Лхагва

Судлаач оюутанд цуврал лекц II, цахим

11 дүгээр сарын 09-25 Лхагва- Баасан

Төгсөгчдийн мөшгөх судалгаа явагдана.

11 дүгээр сарын 19, Бямба

⁴ Гадаад харилцаа хамтын ажиллагааны алба

⁵ Биеийн тамирын тэнхим

⁶ Гадаад хэлний сургууль

“Дэвжээ” уралдаан \Оюутны байр\
11 сарын 24, Пүрэв

Их Эзэн Чингис хааны өдөр, Амралтын өдөр

11 дүгээр сарын 26, Бямба

Бүгд Найрамдах Улс тунхагласан өдөр

12 сар, 2022

Дх	XIV	XV	XVI		
----	-----	----	-----	--	--

Д		5	12	19	26
М		6	13	20	27
Л		7	14	21	28
П	1	8	15	22	29
Б	2	9	16	23	30

Б	3	10	17	24	31
Н	4	11	18	25	

12 дугаар сарын 01, Пүрэв

Дох-той тэмцэх дэлхийн өдөр \ЭМТ, ЗУЗ клуб\

12 дугаар сарын 01- 30, Пүрэв-Баасан

Төгсөгчид “Төгсөх оюутны анкет”-аа онлайнаар бүртгүүлнэ.

12 дугаар сарын 09, Баасан

Оюутны клубүүдийн тайлан хэлэлцэх хурал

12 сарын 26 – 1 сарын 06, Даваа - Баасан

Намрын улирлын кредитийн урамшуулал авах оюутны материал ОСҮА-нд хүлээн авна.

12 дугаар сарын 29, Мягмар

Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр, Амралтын өдөр

01 сар, 2023

Дх					I	II
----	--	--	--	--	---	----

Д		2	9	16	23	30
М		3	10	17	24	31
Л		4	11	18	25	
П		5	12	19	26	
Б		6	13	20	27	

Б		7	14	21	28	
Н	1	8	15	22	29	

01 дүгээр сарын 09 - 13, Даваа - Баасан

Ректорын нэрэмжит тэтгэлэгт “Шилдэг төгсөгч” оюутны материал хүлээн авна.

01 сарын 24 – 25, Мягмар - Лхагва

Төгсөгчдөд диплом гардуулах ёслолын ажиллагаа

01 дүгээр сарын 09-16, Даваа-Баасан

2022-2023 оны намрын улирлын кредитийн урамшууллын тушаал гарна

ХАВРЫН УЛИРАЛ

02 сар, 2023

Дх	I	II	III	IV	V
Д		6	13	20	27
М		7	14	21	28
Л	1	8	15	22	
П	2	9	16	23	
Б	3	10	17	24	
Б	4	11	18	25	
Н	5	12	19	26	

02 дугаар сарын 06-10, Даваа-Баасан

Клубийн нэгдсэн өдөрлөг /КНЗ/

02 дугаар сарын 15, Лхагва

Судлаач оюутанд цуврал лекц III, цахим

03 сар, 2023

Дх	V	VI	VII	VIII	IX
Д		6	13	20	27
М		7	14	21	28
Л	1	8	15	22	29
П	2	9	16	23	30
Б	3	10	17	24	31
Б	4	11	18	25	
Н	5	12	19	26	

01 дүгээр сарын 23 - 02 дугаар сарын 03, Даваа - Баасан

Баян-Өлгий, Увс, Завхан, Говь-Алтай, Ховд, Дорнод, Сүхбаатар, Хөвсгөл, Баянхонгор, Өмнөговь аймгуудаас суралцаж буй оюутнууд замын зардал нөхөн авахад шаардагдах бичиг баримтыг Сургалтын албанд бүрдүүлж өгнө. \500 км-ээс дээш\

01 дүгээр сарын 23 – 2 дугаар сарын 10, Даваа - Баасан

Оюутнууд эрүүл мэндийн даатгалын сунгалт хийнэ.

02 сарын 21 – 23, Мягмар - Пүрэв

Хаврын тэргүүн сар, Цагаан сарын баяр, Амралтын өдөр

02 дугаар сарын 13 - 17, Даваа - Баасан

Оюутан цэрэг хөтөлбөрийн бүртгэл явагдана. \Бүрэлдэхүүн сургууль\

03 дугаар сарын 01-31, Лхагва -Баасан

“Хотын соёл” аян /ОСҮА, КНЗ, БуХС, ЦЕГ/

03 дугаар сарын 07- 10, Мягмар- Баасан

Дээлтэй ШУТИС өдөрлөг

03 дугаар сарын 07, мягмар

Судлаач оюутанд цуврал лекц IV, цахим

03 дугаар сарын 07-18 Даваа-Баасан

Оюутны эрдэм шинжилгээний бага хурал \Бүрэлдэхүүн сургуулиудад зохион байгуулагдана.\

03 дугаар сарын 09 -05 сарын 11, Лхагва

“Ажил эрхлэлтэд чиглүүлэх” модуль сургалт /Төгсөх ангийн оюутнууд/

03 дугаар сарын 10, Лхагва

“Зочны цаг” уулзалт лекц, цахим

03 дугаар сарын 02-09, Лхагва - Лхагва

“Таны эрүүл мэндийн боловсролд” сургалт, өдөрлөг /ЭМСТ, ОХ, КНЗ/

03 дугаар сарын 08, Лхагва

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Амралтын өдөр

03 дугаар сарын 11, Баасан.

Номын нээлт. Зохиогч-уншигчийн уулзалт, ярилцлага /ШУТНС/

03 дугаар сарын 11 -12, Бямба-Ням

Оюутны спортын тэмцээн \Оюутны байр,ОХ\

03 дугаар сарын дугаар 23, Лагва

“Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр” /СБД, ЭМСТ/

03 дугаар сарын 25- 26, Баасан-Бямба

ШУТИС-ийн оюутны “Урлагийн XX их наадам”

03 сарын 23, Лхагва

“Оюутан залуучуудын нийгмийн оролцоо, хөгжил” хэлэлцүүлэг \E-604 тоот-КНЗ\

03 сарын 28, Даваа

Оюутны эрдэм шинжилгээний бага хурлаас шалгарсан илтгэлийн материалыг хүлээн авна.\ОСҮА\

03 сарын 30, Лхагва

“Ажлын байрны эрэлт хэрэгцээнд гарч буй өөрчлөлт” лекц \хурлын танхим\, цахим

03 дүгээр сарын 31, Баасан

ШУТИС-ийн оюутны “Урлагийн XX их наадам” Гала тоглолт

04 сар, 2023

Дх	IX	X	XI	XII	XIII
----	----	---	----	-----	------

Д		3	10	17	24
М		4	11	18	25
Л		5	12	19	26
П		6	13	20	27
Б		7	14	21	28

Б	1	8	15	22	29
Н	2	9	16	23	30

04 дүгээр сарын 01- 05 сарын 30, Бямба –Ням

“Оюутан- Цэрэг” хөтөлбөрийн хичээл явагдана

04 дүгээр сарын 03 -14, Даваа-Баасан

“Соёлын өдөрлөг” аяны арга хэмжээ (БуХС-ХУС, ОСҮА)

04 дүгээр сарын 05, Лхагва

“MUST OPEN MIC” дуулаачийн клуб

04 дүгээр сарын 07- 14 , Баасан- Баасан

“Эрүүл зөв, хооллолт”-ын сургалт аян, цахим

04 дүгээр сарын 07, Баасан

ШУТИС-ийн оюутны эрдэм шинжилгээний

“Эрдмийн XXII нэгдсэн” чуулган шилдэг илтгэлийн уралдаан

04 дүгээр сарын 10 – 21, Даваа - Баасан

Төгсөгчид “Төгсөх оюутны анкет”-аа онлайнаар бүртгүүлнэ.

04 дүгээр сарын 17 - 21, Даваа – Баасан.

Дэлхийн номын өдөр. Номын үзэсгэлэн, худалдаа /ШУТНС/

04 дүгээр сарын 17 – 28, Даваа – Баасан.

“Сумитомо” корпорацийн тэтгэлэгийн материал хүлээн авна /ГХХАА/

04 дүгээр сарын 28, Баасан

ШУТИС-ийн оюутны эрдэм шинжилгээний “Эрдмийн XXII нэгдсэн” чуулган “Оюутны шилдэг бүтээлийн үзэсгэлэн” шилдэг бүтээл шалгаруулна.

04 сарын 10-14, Даваа-Баасан

Ажил олгогчдын нэгдсэн өдөрлөг

04 дүгээр сарын 10-14, Пүрэв-Баасан

“Монгол инженер-2023” ЕБС-ийн сурагчдад мэргэжил сурталчилах өдөрлөг

04 сарын 10 - 28, Даваа - Даваа

Монгол улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгийн материал хүлээн авна.

04 сарын 17-21, Даваа- Баасан

ШУТИС-ийн оюутнуудын дунд “Монгол бичгийн олимпиад” /ОСҮА, ГХС/

04 сарын 19, Лхагва

Залуу инженер – лекц \ хурлын танхим\

04 сарын 20-22, Лхагва- Баасан

“Дэлхийн номын өдөр” гадаад номын үзэсгэлэн, худалдаа\ ШУТТНС\

04 дүгээр сарын 22-23, Бямба-Ням

“Сайн үйлсийн” аян / ОХ, КНЗ/

04 дүгээр сарын 28, Баасан

“Оюутны хавар” тайлан тоглолт /Урлагийн клуб, оюутны дуу бүжгийн чуулга/

04 сарын 24-28, Даваа-Баасан

Дархлаажуулалтын аян \ЭМТ\

04 сарын 27-5 сарын 05, Пүрэв-Баасан

Эко боловсролын аян \ОХҮА, Бүрэлдэхүүн сургууль, клубүүд\

05 сар, 2023

Дх	XIV	XV	XVI		
----	-----	----	-----	--	--

Д	1	8	15	22	29
М	2	9	16	23	30
Л	3	10	17	24	31
П	4	11	18	25	
Б	5	12	19	26	

Б	6	13	20	27	
Н	7	14	21	28	

05 сарын 10-12, Лхагва-Баасан

“Донорын өдөрлөг” хүмүүнлэгийн аян \ЭМСТ\

05 сарын 12, Баасан

Оюутны клубүүдийн тайлан хэлэлцэх нэгдсэн хурал
\ОСҮА, КНЗ\

05 сарын 22 –06 сарын 15, Даваа - Баасан

Төгсөгчдийн мөшгөх судалгаа явагдана.

06 сар, 2023

Дх					
----	--	--	--	--	--

Д		5	12	19	26
М		6	13	20	27
Л		7	14	21	28
П	1	8	15	22	29
Б	2	9	16	23	30

Б	3	10	17	24	
Н	4	11	18	25	

06 сарын 05 -19, Даваа-Даваа

Кредитийн урамшуулал авах оюутны материалыг хүлээн вна.\ОСҮА\

6 сарын 12 - 16, Даваа - Баасан

Ректорын нэрэмжит тэтгэлэгт “Шилдэг төгсөгч” оюутны материал хүлээн авна. \ОСҮА\

06 сарын 20 - 21, Мягмар-Лхагва

Төгсөгчдөд Диплом гардуулах ёслолын ажиллагаа

2. Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа

Их сургуулийн оюутны эхний жилд шинэ оюутанд чиглэсэн хөтөлбөр үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдан суурь ур чадвараа авсан оюутан та суралцах хугацаандаа сургуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй Оюутны холбоо, оюутны зөвлөл, клубийн нэгдсэн зөвлөл, мэргэжлийн болон сайн дурын урлагийн клубүүдэд өөрийн хүсэл сонирхол, авьяас чадвараа хөгжүүлэхээр хамрагдах.

Өөрөө санаачлан клуб байгуулах зэргээр идэвх санаачлагатай аливаа үйл ажиллагаанд өөрийгөө дайчлан сурсан мэдсэн зүйлээ хөгжүүлэх боломжтой болно. Ингээд та бүхэнд дээрх байгууллагуудын үйл ажиллагааг товчхон танилцуулъя.

ШУТИС-ийн Оюутны Холбооны танилцуулга

Эрхэм зорилго

Сургуулийн эрхэм зорилготой нийцүүлэх үүднээс нийт оюутнуудын эрх ашгийг хамгаалах, нийгмийн идэвх бүтээлч сэтгэлгээг дэмжих, бүх төрлийн мэдээллээр хангаж, сурч боловсрох цаашлаад хөдөлмөр эрхлэхэд бодит хувь нэмэр оруулна. Мөн “Оюутны эрхийн түгээмэл тунхаглал”-ын үзэл санааг хэрэгжүүлэх түүнд заасан эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино.

Үйл ажиллагаа

Оюутнуудын нийтлэг хүсэл эрмэлзэлд тулгуурлан урлаг спорт, олон нийтийн уралдаан тэмцээн, эрдэм шинжилгээний хурал, сайн дурын үйл ажиллагааг урданд зохион байгуулдаг байна.



Оюутны санаачлагаар бий болсон клубийн тухай:

Их сургуульд оюутан залуусын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжтой үйл ажиллагааны нэг бол клубийн үйл ажиллагаа байдаг. ШУТИС-д мэргэжлийн, сайн дурын, урлагийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг 50 гаруй клубүүд байдаг. Клубүүдийн үйл ажиллагааг сургуулийн зүгээс дэмжин туслан хамтран ажилладаг. Шинэ оюутан та өөрийн сонирхсон клубүүдийн талаарх мэдээллийг дэлгэрнгүй авч өөрийнхөө сонирхол, хүсэл, тэмүүлээр өөрийгөө хөгжүүлэх боломжтой болохыг танд мэдээллэж байна. Клубүүдийн үйл ажиллагаатай танилцах цахим хаяг: <http://must.edu.mn/mn/clubuud/> (Шинэ оюутан танд туслах хичээлийн хоцрогдол арилгахад чиглэсэн “Багшийн туслах оюутан” клубийн үйл ажиллагааг сонирхоорой, хамрагдаарай.) хаягаар орж клубүүдийн эрх, үүрэг болон клубүүдийн танилцуулга, тайлантай танилцах боломжтой.

3. Төгсөгчдөд чиглэсэн үйл ажиллагаа

Их сургууль төгсөгчдийг ажил эрхлэлтэд чиглүүлэх сургалтын хөтөлбөрийн зорилго нь төгсөгчдөд ажлын байрны шаардлага хангахад бэлтгэх, дэлхийн иргэн болоход чиглэсэн олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тус хөтөлбөрийн зорилго оршино. Хөтөлбөрт бүрэн хамрагдсан шилдэг төгсөгчдөд “Батламж”-ийг дипломын хамт олгодог. Хөтөлбөрийг цахим болон танхимаар хүргэдэг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ШУТИС-ийн Оюутны соёл, үйлчилгээний алба, MSDI-Pro HR аутсорсинг консалтинг компани, БУХС-ийн МС-ийн багш нарын “Алтангадас” клуб хамтран ажилладаг.

ШУТИС-ИЙН ТӨГСӨГЧДИЙГ АЖИЛ ЭРХЛЭЛТЭД ЧИГЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Хичээлийн 7 хоног,	Сэдэв	Агуулга	Хугацаа /90 мин/
VIII долоо хоног	Удиртгал	Төгсөгчдийг ажил эрхлэлтэд чиглүүлэх сургалтын зорилго, хөтөлбөр, үр дүн “Алтангадас” клубийн үйл ажиллагаа Тогтвор суурьшилтай ажлын байрны шаардлага хангахад анхаарах нь	2

IX долоо хоног	Ажилд орох хүсэлт гаргах, ярилцлагад бэлтгэе	- Ажлын байрны шаардлага - CV танилцуулга бэлтгэх - Ур чадварт суурилсан товч намтар - Ажилд орох ярилцлагын төрөл, хэлбэр - Ажилд орох ярилцлагын хувийн бэлтгэл /хувцаслалт, биеийн хэлэмжүүд/	2
X долоо хоног	Карьераа хөгжүүлэе	- Хувь хүний төлөвлөлт - Ур чадвар, дадал - Сургалт, хөгжил	2
XI долоо хоног	Бусдад өөрийгөө таниулыя	- Хэрхэн хамт олны гишүүн болох - Байгууллагад хэрхэн нийгэмших - Багаар ажиллах	2
XII долоо хоног	Ажил олгогчтойгоо танилцъя	- Байгууллага, ажлын орчин нөхцөлтэй танилцах - Ажлын байрны шаардлага, тодорхойлолт - Байгууллагын дүрэм, журам	2
XIII долоо хоног	Энгейжментээ мэдрье	- Ажилдаа сэтгэлтэй хандах - Өөрийгөө хөгжүүлэх - Байгууллага, ажилтанд тавих анхаарал халамж	2
XIV долоо хоног	Байгууллагатай танилцъя	- Байгууллагын танилцуулга - Бүтээгдэхүүн, үйлчилгээ - Байгууллагын гүүх, зорилго - Байгууллагын нэр хүнд	2
XV долоо хоног	Дэлхийн иргэн болох	- Мэдээллийн технологи - Ажиллах орчин - Хувь хүний бэлтгэх	2

ХVI долоо хоног	Нэгдсэн семинар	- Бататгах сургалт - CV зөвлөгөө, мэдээлэл	2
Тусгай хуваарийн дагуу	MUST network- ing event зохион байгуулах	Ажил олгогчдын хүний нөөцийн менежерүүдтэй ажлын ярилцлага хийх	2
Нийт сургалтын цаг			20

Оюутнуудад ШУТИС-ийн **MUST.EDU.MN** сайтын **ОЮУТАН** линкд хувь хүний хөгжил, төлөвшилд чиглэсэн сургалтуудыг бэлтгэн цахимаар хүргэх боломжийг бүрдүүлсэн. Үүнд

ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ТӨЛӨВИЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ДОТОР

- **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, СЕМИНАР**

- **ОЮУТАН ТАНД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ, МЭДЭЭЛЛҮҮД**

нийт 27 цахим сургалт тавигдсан байгаа та бүхэн судлаж өөрт мэдлэг мэдээлэл болгон ашиглах болмжтой.

ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ, САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

Оюутны хөгжлийн зээл

Боловсролын Зээлийн Сангийн “Оюутны хөгжлийн зээл”-ээр анх удаа суралцах оюутнууд нь дараах нөхцлийг хангасан байх ёстой.

- Тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр анх удаа бакалавр, магистр, докторын шатлалд суралцаж байгаа Монгол Улсын иргэн байх;

Тавигдах ерөнхий шаардлага:

- Бакалаврын хөтөлбөрт шинээр элсэгчийн элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо 600 болон түүнээс дээш байх;
- Өдрийн ангид суралцаж байгаа бакалаврын хөтөлбөрийн оюутны голч дүн 2,8 болон түүнээс дээш байх;
- Өдрийн ангид суралцаж байгаа магистрант, докторантын голч дүн 3,2 болон түүнээс дээш байх;
- Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгэгдсэн байх;

“Оюутны хөгжлийн зээл”-д шинээр хамрагдах хүсэлтэй тэргүүлэх мэргэжлийн суралцагч холбогдох материалаа <https://www.must.edu.mn/mn/news/10203> хаягаар судлан бүрдүүлж, бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын албаны хариуцсан ажилтанд өгнө.

Сургалтын төлбөрийн тэтгэлэг

Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг буюу сургалтын төлбөрийн тэтгэлэг (буцалтгүй тусламж)-ээр суралцах оюутан нь дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгэлтэй байх шаардлагатай.

Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжид хамрагдах шаардлага хангасан суралцагч дараахь бичиг баримтыг бүрдүүлж, бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албаны хариуцсан ажилтанд өгнө.

Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 264 дүгээр тогтоолын дагуу төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт ШУТИС-ийн дараах суралцагч хамрагдана.

Үүнд:

- Бүтэн өнчин суралцагч;
- Бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцагч хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрт суралцагч;
- Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрийн нэг суралцагч;
- Цаатан өрхийн бакалаврын хөтөлбөрт суралцагч;
- Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэн;
- Нэг гэр бүлийн 3 болон түүнээс дээш хүүхэд дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрт зэрэг суралцаж байгаа тохиолдолд 1 суралцагч;

Буцалтгүй тусламжийн бүрдүүлэх материалуудыг <https://www.must.edu.mn/mn/news/10204> судлан бүрдүүлж албан бичгийн шаардлага хангасан байдлаар бэлтгэн, намрын улиралд 2022 оны 8 дугаар сарын 22-ноос 9 дүгээр сарын 02, хаврын улиралд 2023 оны 1 дүгээр сарын 23-наас 2 дугаар сарын 03-ны өдрүүдэд БС-ийн сургалтын албаны хариуцсан ажилтанд өгнө.

ГАДААД, ДОТООД ТЭТГЭЛЭГ, ХӨТӨЛБӨР

Сурлага, сахилга батаар тэргүүний, амьдралын боломж муутай, төлбөрийн чадамжгүй, техник сэтгэлгээтэй, авьяас чадвартай шилдэг тэргүүний оюутнуудыг дэмжихэд тэтгэлгийн зорилго оршдог.

Ерөнхий тавигдах шаардлага:

- ҮГД 3.00-иас болон түүнээс дээш суралцагч оюутан байх;
- Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, сургалтын төлбөрийн хувьд санхүүгийн дэмжлэг шаардлагатай оюутан байх;
- Онцгой авьяастай, техник сэтгэлгээтэй, эрдэм шинжилгээний хурал, урлаг, спортын арга хэмжээнд идэвхитэй оролцдог байх;

№	Тэтгэлэгийн нэр	Тэтгэлэг олгогч байгууллага	Зарлагдах хугацаа
1	Монгол улсын Ерөнхийлөгчийн болон ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг	Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Тухайн саруудад
2	ШУТИС-ийн Ректорын нэрэмжит тэтгэлэг	ШУТИС	8 сарын сүүлийн 7 хоног
3	ШУТИС-Тоёото сан тэтгэлэг	ШУТИС, Тоёото корпораци	10 сарын эхний 7 хоног
4	Сумитомо корпорацийн нэрэмжит тэтгэлэг	Сумитомо корпорацийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар	2 сарын эхний 7 хоног
5	Мицубиши Корпораци	Мицубиши Корпорацийн Монгол дахь төлөөлөгчийн газры	10 сарын эхний 7 хоног
6	Санко группын нэрэмжит тэтгэлэг	Санко групп	9 сарын эхний 7 хоног
7	Голомт банкны нэрэмжит оюутны тэтгэлэг хөтөлбөр	ломт банк	9 сарын эхний 7 хоног
8	Их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан тэтгэлэгт хөтөлбөр	Швейцарийн хөгжлийн агентлаг, Зориг сан	9 сарын сүүлийн 7 хоног

9	Оюу Толгой компани Үндэсний тэтгэлэгт хөтөлбөр	Оюу толгой компани	9 сарын эхний 7 хоног
---	--	--------------------	--------------------------

ЗАМЫН ЗАРДЛЫН НӨХӨН ОЛГОЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн тогтоолын дагуу оршин суудаг газраасаа 500 километр болон түүнээс хол байршилтай их, дээд сургууль, коллежид зохих журмын дагуу элсэн суралцагчдын өвлийн амралтаар орон нутаг руугаа явсан, ирсэн 2 талын зардлыг холбогдох баримтыг нь үндэслэн авто тээврийн хэрэгслийн тарифаар тооцож Боловсролын зээлийн сангаас олгодог.

Авто тээврийн хэрэгслээр зорчих тасалбар, цахим үнэмлэхний хуулбар, онгоцны тийз болон онгоцоор ниссэн оюутнуудын хувьд ниссэн эсэх лавлагааг ниссэн компаниаасаа авч 2 дугаар сарын эхний 7 хоногт багтаан сургалтын албандаа өгч замын зардал нөхөн авах тооцоог Боловсролын зээлийн сантай хийж санхүүжилт орж ирсний дараагаар замын зардлаа нөхөн авдаг.

Оюутны байрны танилцуулга

ШУТИС-нь оюутны таван байртай нийт 1000 гаруй оюутан хамруулах хүчин чадалтай оюутны байранд ихэвчлэн I-II курсийн оюутнуудыг түлхүү хамруулдаг. <http://must.edu.mn/beta3/menu479>

Оюутны байруудын байршил

- Оюутны I-р байр – Сүхбаатар дүүрэг хуучнаар Дашчойлин хийдийн зүүн талд
- Оюутны III-р байр – Баянзүрх дүүрэг 15-р хороо /Сансарын аюулгүйн тойргийн хойно/
- Оюутны IV байр - Баянзүрх дүүрэг 5-р хороо
- Оюутны V байр - Хан-Уул дүүрэг 3-р хороо /Алтай хотхоны зүүн урд/

Оюутны байранд амьдрах оюутны бүртгэл хичээл эхлэхийн өмнөх долоо хоногт цахимаар явагдана.

ОЮУТАН ТАНД ШААРДЛАГАТАЙ ДҮРЭМ ЖУРАМ

Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам- Тус журам нь оюутан таны сурах үйл ажиллагаатай холбоотой бүхий л асуудлыг зохицуулахаар тусгагдсан байдаг.

Та бүхэн <https://www.must.edu.mn/mn/page/430> дэлгэрэнгүйтэй танилцах боломжтой

Шилдэг оюутан шалгаруулах журам

Нийтлэг үндэслэл:

ШУТИС-ийн төгсөгчид сэтгэн бодож, оновчтой шийдвэр гаргах чадвартай, харилцааны өндөр соёлтой, нийгмийнхээ өмнө хүлээх хариуцлагаа бүрэн ухамсарласан байна гэсэн сургалтын эрхэм зорилгод хүрэхийн тулд оюутны сурах идэвхи чармайлт, сурлагын чанарыг дээшлүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

ШУТИС-ийн дүрэм, дотоод журмыг чандлан биелүүлсэн, нийгмийн идэвхи санаачлагатай, сурлагын өндөр амжилт гаргасан тэргүүний оюутныг энэхүү журмыг баримтлан шалгаруулан урамшуулах болно. Цахим хаяг: https://www.must.edu.mn/mn/rectoriin_neremjit/ дэлгэрэнгүйтэй танилцана уу.

Оюутнуудад кредитийн урамшуулал олгох журам

Нийтлэг үндэслэл

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн оюутнуудын нийгмийн идэвх, оролцоог дээшлүүлэх, тэдний авъяас чадвар, хүсэл сонирхлыг нь урамшуулан дэмжих, хөгжүүлэх зорилгоор сурлага, эрдэм шинжилгээ, урлаг, спортын онцгой амжилт гаргасан шилдэг оюутнуудад урамшуулал олгох үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Урамшууллын төрлүүд

ШУТИС-ийн нэрийн өмнөөс олон улс, улс, бүс нутаг, их дээд сургуулиудын дунд зохиогдож байгаа эрдэм шинжилгээний хурал, олимпиад, спорт, урлагийн уралдаан тэмжээн, наадмуудад холбогдох нэгж, сургууль, захирлын зөвшөөрлийн дагуу амжилттай оролцож эхний гурван байранд шалгарсан, захирлын нэрэмжит хуудсанд бичигдсэн болон оюутны клуб, оюутны холбоо, оюутны зөвлөлийн үйл ажиллагаанд оролцсон байдлыг үнэлэн урамшууллыг оюутнуудад олгоно.

(Тэмцээн, уралдааны нэр төрлийг давхцуулан олгохгүй)
https://www.must.edu.mn/mn/credit_uramshuulal/ дэлгэрэнгүйтэй танилцана уу.

Оюутны ёс зүйн дүрэм

Нийтлэг үндэслэл

1.1 Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуульд суралцаж буй оюутны эрх, үүргийг баталгаажуулах, даяаршлын эрин үеийн шаардлагад нийцэхүйц ёс зүйн өндөр ухамсар, соёлтой боловсон хүчин бэлтгэх

1.2 Оюутан, сургуулийн захиргаа хамт олны хооронд үүсэх ёс зүйн харилцааг төлөвшүүлэх, гаргасан зөрчилд хариуцлага хүлээлгэх

1.3 Энэхүү дүрэмд заасан “Оюутан” гэдэг нь ШУТИС-д элсэн орох болзлыг

хангаж тус сургуулийн “Бакалавр”-ын болон “Магистр”-ийн зэрэг горилон суралцаж буй хуулийн этгээд болно. <https://www.must.edu.mn/mn/b3m614/> дэлгэрэнгүйтэй танилцана уу.

ОЮУТАН ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ

Оюутны хөдөлмөр эрхлэлт:

Орлоготой оюутан хөтөлбөрийн тухай:

Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор “Орлоготой оюутан хөтөлбөр”-ийг баталсан билээ. “Орлоготой оюутан” хөтөлбөрийн зорилго нь оюутанд цагийн ажил эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Нийслэлийн хөдөлмөр, эрхлэлтийн газартай байгуулсан санамж бичгийн хүрээнд оюутнуудыг байнгын болон цагийн ажлын байранд зуучилдаг.

Оюутны соёл, үйлчилгээний албаны фэйсбүүк фэйж хуудсанд аж ахуй нэгж байгууллагуудаас ирсэн нээлттэй ажлын байрны саналыг тогтмол мэдээллэж, ажлын байранд зуучилж ажилладаг.

Оюутны Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагддаг ажлууд:

Хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх, хөдөлмөрийн ур чадвар мэдлэг мэдээлэл олгох сургалт, байнгын болон цагийн ажлын байрны зуучлал

Ажил олгогч байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах, мэдээллийн сан үүсгэх

Оюутан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өдөрлөг яармаг зохион байгуулах

Дэлгэрэнгүйг <https://www.must.edu.mn/mn/page/444> үзнэ үү.

Соёл, урлагийн үйлчилгээ:

Үндэсний уламжлалт ардын урлаг, орчин үеийн хөгжмийн урлагийг олон нийтэд таниулан сурталчилах, хадгалан хамгаалах, залгамж үеийнхэндээ өвлүүлж урын сантай болох, оюутан залуусын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, хүсэл сонирхол, авьяас чадварыг хөгжүүлэх, гоо зүйн мэдрэмжийг дээшлүүлэх, урлагаар дамжуулан соёлд төлөвшүүлэх, урлагийн авьяастай хамт олон бий болгох зорилгоор өөрсдийн нөөц боломжинд тулгуурлан Оюутны соёл, үйлчилгээний албаны дэргэд “ШУТИС-ийн Залуус” оюутны дуу бүжгийн чуулга байгуулагдсан. Дэлгэрэнгүйг <https://www.must.edu.mn/mn/page/715> үзнэ үү.

Энэхүү чуулгын дэргэд ардын бүжиг, үндэсний хөгжим, дуулаач, цэнгээнт болон чөлөөт бүжиг, хөтлөгч гэх мэт оюутан залуусын хүсэл сонирхлоор тулгуурлан байгуулагдсан клубүүд тогтмол үйл ажиллагаагаа явуулж байна. Оюутан залуус та бүхнийг чөлөөт цагаараа авьяас чадвараа хөгжүүлж, үнэ

төлбөргүй суралцах боломжоор ханган ажиллаж байна. Дэлгэрэнгүйг <https://www.must.edu.mn/mn/urlagiin%20club/> үзнэ үү.

Оюутан цэрэг хөтөлбөрийн талаар:

Монгол Улсын их, дээд сургуулийн оюутнуудыг суралцах хугацаанд нь цэргийн эрчимжсэн сургалттай тусгай хөтөлбөрөөр цэргийн бэлтгэл сургалтад хамруулан цэргийн алба хаалгах бололцоог бүрдүүлэх, эх орноо батлан хамгаалах, төрийн алба хаших, эрүүл чийрэг, бие бялдар, сэтгэл зүйн болон цэргийн бэлтгэлтэй залуусын тоог нэмэгдүүлж, улс орныг батлан хамгаалах чадавхийг сайжруулан дайчилгааны бэлтгэл үүрэгтний нөөцийг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино. <https://www.must.edu.mn/mn/oyutan-tsereg-khotolbor/> дэлгэнгүй мэдээллийг авна уу.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдах тухай:

Шинжлэх ухаан, технологийн их сургууль нь Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран оюутан суралцагчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах гэрээ байгуулан ажилладаг. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3-т оюутан, суралцагчдын эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг сургуулийн захиргаа хариуцан зохион байгуулна гэж заасны дагуу тус хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс 19 насанд хүрсэн бүх суралцагчид сарын 4200, жилийн 50400 төгрөгийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх үүрэгтэй. Дэлгэрэнгүйг <https://www.must.edu.mn/mn/eruul-mendiin-daatgal/> үзнэ үү. Та эрүүл мэндийн даатгалаа төлснөөр төрөөс үзүүлж буй үйлчилгээг бүрэн аях болон өөрийн эрүүл мэндээ хамгаалах гол эх үүсвэр болох тул ЭМД-аа заавал хамрагдах нь танд олон талын ач холбогдолтой шүү.

Нийтийн тэвэрээр хөнгөлөлттэй зорчих тухай:

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 6/21 тоот тогтоолоор баталсан “Их, дээд сургууль, Коллеж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагч, оюутанд нийтийн тэвэрийн “Цахим төлбөрийн карт” олгох, цэнэглэх, ашиглахад баримтлах журам-ын дагуу тухайн хичээлийн жилд хөнгөлөлттэй зорчих оюутнуудад шинээр карт олгох болон эрх сунгах ажлыг зохион байгуулдаг.

Хичээлийн жил бүр шинээр батлагдсан квотын захиргаанаас хяналт тавин бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албад цахим карт шинээр авах, сунгах ажлыг зохион байгуулдаг.

Дэлгэрэнгүйг <https://www.must.edu.mn/mn/niitiin%20teeveriin%20card/> үзнэ үү.

ШУТТөв номын сангийн тухай:

Манай номын сан анх 1967 онд МУИС-ийн Эдийн Засгийн Дээд Сургуулийн номын сангийн бааз дээр анх байгуулагдсан. ШУТИС-ийн номын сан нь ШУТТөв болон бүрэлдэхүүн сургуулиудын /БуХС, МХТС, МехТС, ҮТС, ДаТС, ОрТС/ номын сангаас бүрдсэн салбар номын сантай, 2240 уншигчийн суудал, 340,000 орчим хэвлэмэл болон цахим ном, хэвлэл, материал, 54 номын санчтай үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс ШУТТНС нь 900 гаруй уншигчийн суудал, 15 үйлчилгээний нэгж, 140,000 орчим ном, хэвлэлийн сан хөмрөгөөр уншигчдад үйлчилж байна. Номын сангийн <http://library.must.edu.mn/> вебсайтаар дамжуулан мэдээ мэдээлэл, цахим үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Уншлагын танхим I/6 давхарт 603тоот/

Тус танхим нь ГУУС, ХШУС, МехТС-ийн оюутнуудад үйлчилгээг хүргэдэг. Ойрын фондондоо геологи, уул уурхай, механикийн мэргэжлийн болон ерөнхий эрдмийн 9,573 ном, сурах бичигтэй. 110 уншигчийн суудалтай, 09-21.00 цагийн хооронд 2 ээлжээр 3 номын санч ажилладаг.

Уншлагын танхим II/5 давхарт 504 тоот/

Тус танхим нь ЭХС, БуХС, ГХИ, МХТС-ийн оюутнуудад үйлчилгээг хүргэдэг. Ойрын фондондоо тvvх, нийгмийн ухаан, эрчим хүчний мэргэжлийн болон ерөнхий эрдмийн 9,839 ном, сурах бичигтэй. Нийт 200 суудалтай, 09-21.00 цагийн хооронд 2 ээлжээр 4 номын санч ажилладаг.

Уншлагын танхим III/3 давхарт 304тоот/

Тус танхим нь БАС, ҮТС, ДаТС-ийн оюутнуудад үйлчилгээг хүргэдэг. Ойрын фондондоо хүнс биотехнологи, барилга, архитектур, математикийн мэргэжлийн болон ерөнхий эрдмийн 11,908 ном, сурах бичигтэй. 220 уншигчийн суудалтай, 09-21.00 цагийн хооронд 2 ээлжээр 4 номын санч ажилладаг.

Эрдэм шинжилгээний уншлагын танхим /6 давхарт 602 тоот/

Тус танхим нь профессор багш нар болон төгсөх курсын оюутнуудад үйлчилгээг хүргэдэг. Ойрын фондондоо 8,957 эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон ном материалтай.

Тогтмол хэвлэлийн уншлагын танхим /4 давхарт 406 тоот/

Тус танхим нь нийт оюутнуудад 7,000 орчим мэргэжлийн болон танин мэдэхүйн сэтгүүл, сонин хэвлэлээр үйлчилгээг хүргэдэг. 40 уншигчийн суудалтай.

Цахим уншлагын танхим /5 давхарт 503 тоот/

Тус танхим нь уншигчдыг цахимаар ном, сурах бичгийг унших боломжийг бүрдүүлдэг. <https://must.lib4u.net/> хаягаар оюутны код, нууц үгээр нэвтрэн орж гэрээсээ болон хаанаас ч цахим ном, материалыг унших боломжтой. Нууц үгийг номын санчаас авах шаардлагатай.

Гэрээр ном олгох фондууд /2 давхарт 201, 205 тоот/

Номын сангийн 2 давхарт гэрээр ном олгох фондууд байрлана. Фондуудаас 3-7 хоногоор мэргэжлийн ном, сурах бичгүүдээ гэрээр авна.

БУХС, ДаТС, МХТС, МехТс, ОрТСургуулийн салбар номын сангууд тухайн сургуулийн хичээлийн байрандаа үйл ажиллагаа явуулж, оюутнууддаа үйлчилгээг хүргэдэг.

Номын сангийн электрон каталогийн хаяг: <https://must.lib4u.net/>

Эрүүл мэнд, спортын төвийн тухай:

ШУТИС-ийн Эрүүл мэнд, спортын төв нь орчин үеийн оношлогооны иж бүрэн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд нийт багш, ажилтан оюутнуудад үйлчилдэг тусгай зөвшөөрөлтэй эмнэлэг юм. Багш, ажилчид, оюутнуудын эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх зорилгоор дотор, уламжлалт болон нөхөн сэргээх, физик эмчилгээ, шүдний урьдчилан сэргийлэх кабинетуудад үйл ажиллагаа явуулдаг. Мөн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, Механик, тээврийн сургууль, Мэдээлэл, холбооны технологийн сургуулиудад их эмчийн салбар ажилладаг.

Тус төв нь шинээр элсэгч оюутнуудыг урьдчилан сэргийлэх нарийн мэргэжлийн төлбөртэй үзлэгт хамруулан картжуулж нэгдсэн сүлжээнд оруулдаг. Эдгээрээс тодорхой оюутнуудыг өөрсдийн эмнэлгийн хяналтанд авч, тэднийг эрүүлжүүлэх үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийт оюутнуудыг сургуульд сурч байх хугацаанд нь үнэ төлбөргүй анхны тусламж үзүүлдэг. ЭМТ-өөс явуулж буй үйл ажиллагааг <http://must.edu.mn/beta3/menu477> албан ёсны face хаяг-<https://www.facebook.com/pages/>

ЗӨВЛӨМЖ

Танд ахмад багш зөвлөж байна.

Сэтгэл догдлуулсан элсэлтийн шалгалт ард үлдэж хүсэн хүлээсэн оюутан хэмээх эрдмийн далайд хөвөх завиндаа та суулаа. Ийнхүү эрдмийн их аянд орж тодорхой чиглэлээр мэргэжил эзэмших зорилгоор суралцах оюуны хөдөлмөр эрхлэгчийг оюутан гэж нэрлэдэг. Оюутан болсноор та бүгдөрөнхий боловсролын сургуульд суралцах үеийн өдөр тутамын багшийн асуулт, самбарт дуудагдах, хичээл бүрийн ном сурах бичиг бэлэн байх мэтийн энгийн хэвшмэл амьдралын хялбар нөхцөл, орчноос харьцангуй өөр, илүү “чөлөөт” бие даасан хэлбэр бүхий сургалтын орчинд орсоноо мэдрэх болно. Суралцах хөдөлмөр нь бие даан ажиллаж дадах, лекц сонсож түүнийг бичиж тэмдэглэх, туршилт, лабораторийн ба тооцоо, график, дадлагын хичээлүүд нь таны хувьд цоо шинэ хэлбэрийн мөртлөө биеэ их дайчлан ажиллах зэрэг онцлогууд нь оюутан хүний оюуны хөдөлмөрийн өвөрмөц хэлбэр билээ.

Шинжлэх ухаан технологийн эрчимт хөгжлийн эрин үед үйлдвэрлэл, үйлчилгээний олон талт салбарууд улам бүр өөр хоорондоо уялдаа холбоотойгоор хөгжихийн сацуу тэдгээр салбаруудыг уриалан зохион байгуулж цогцлон хөгжүүлэх өндөр мэргэжлийн хүний арвин нөөц ихээхэн шаардагдах болсон. Авьяас билэг арвин, ухаан сэргэлэн идэр залуу насандаа өмнөө тууштай зорилго тавьж, бодитой хөдөлмөрлөхгүйгээр гүн мэдлэг, өндөр боловсрол эзэмшиж чадахгүй нь мэдээж. Тавьсан зорилгоо тууштай хэрэгжүүлэхийн тулд зориг үл шантран, юм бүхнийг цагт нь биелүүлэх, бие хүний зарчимч чанар нь эрдэм мэдлэг эзэмших бодит нөхцөл-эх сурвалж болдог. Хэдийгээр хялбар шийдвэрлэгдэх асуудал байлаа ч цаг хугацаанд нь хөдөлмөр зохион байгуулалт хийхгүй бол аливаа ажил сунжирчгүйцэтгэлийн үр дүн буурна. Үүний нэгэн адил оюутан хүн идэвхигүй, залхуу хойрог байдлаасаа болж багшаас өгсөн даалгаврыг цаг хугацаанд нь хийхгүй өөрийгөө дайчлаагүйгээс дараа дараагийн эзэмших мэдлэгээ хойш тавьж буйтай нэгэн адил. Зарим оюутан их, дээд сургуульд орохдоо сонгосон мэргэжилдээ дуртай эрмэлзлэлтэй байхад зарим нь элссэн дариудаа сонгосон мэргэжилдээ итгэл муутай хандах эргэлзэх тохиолдол байдаг.

Хэрэв та элсэлтийн уралдаант шалгалтаар өөрийн сонирхсон мэргэжлээр орж чадаагүй хэрэгцээт салбарын шаардлагаар өөр мэргэжилд хуваарилагдсан байхад нийгмийнхээ шаардлагын дагуу би суралцах хэрэгтэй гэдгийг хатуу ойлгож жинхэнэ мэргэжилтэн

болохын төлөө тэмцэх нь зөвхөн өөрийн төлөө бус нийгэм, эх орон, хамт олны төлөө гэсэн сэтгэлээр хандаж чадвал сурах мэдэхийн төлөө сонирхол

давамгайлах болно. Сурах хөдөлмөр бол сургагчаас гадна суралцагчаас асар их хөдөлмөр, үлэмжийн хүсэл зүтгэлийг шаардана.

Танд зөвлөх багш зөвлөж байна.

Их сургуулийн оюутан болсон та өөрийн хичээл зүтгэл, хувийн зохион байгуулалтаар ямар оюутан болох вэ гэдэг асуудлыг шийдвэрлэнэ. Та оюутан болохын тулд дараах өртөөчилсөн байдлаар явахад та сайн оюутан болох эхний алхамыг хийнэ.

1-р өртөө: ШУТИС-ийн оюутны гарын авлага. Энэ өртөөнд та оюутны гарын авлагыг нягталж судлана. Үүний тулд 2-5 удаа уншиж сургалтын үйл ажиллагаа, хичээлийн төлөвлөгөө, хичээлийн хуваарь, сорил, шалгалт, дүгнэх дүрэм журмын талаар нэгдсэн ойлголттой болно.

2-р өртөө: Цагийг баримтлах. Та энэ өртөөнд эхний 1-4 долоо хоногийг л хичээл сургалт, хүмүүжлийн аливаа үйл ажиллагаанд нэг ч секунд, минутын хоцрогдолгүй идэвх гарган цагийг нарийн чанд баримтлан, өөрт хэвшил болго.

3-р өртөө Өөрийгөө хөгжүүл. Та энэ өртөөнд хичээлээс гадуур зохион байгуулагддаг оюутны байгууллага, клубүүдийн үйл ажиллагаатай танилцан сонголтоо хийж нэг зүйлд тууштай байж түүнд өөрийгөө зориулах сэтгэлгээний өөрчлөлтийг хий.

4-р өртөө Зөвлөх багштай ойр бай. Та өөрийн зөвлөх баштай байнга холбоотой ажил, аливаа мэдээллийг бүрэн авч өөрийн болго.

Танд сургалтын албаны ажилтан зөвлөж байна.

Оюутан та дараах зүйлийг анхааран суралцах хэрэгтэй.

1. Зөвлөх багштайгаа байнга нягт холбоотой байж зөвлөгөө авах
2. Та нарт их сургуулийн багш ЕБС-ийн багш шиг үргэлж шаардлага тавихгүй, тиймээс оюутнууд хичээлээ хийхгүй налайж яваад хоцордог. Иймээс хичээлээ эхнээс нь сайн хий.
3. Танд хичээл сонголт 1 маш чухал гэдгийг анхаарах хэрэгтэй. Сонголт 1-ийг хийгээгүй тохиолдолд сонголт 2-оо хийж чадахгүй.
4. Хичээл сонголтыг хийхийн тулд сургалтын болон оюутны үйлчилгээний хуанлитай сайн танилцах шаардлагтай. Хуанлид оюутан танд хэрэгтэй мэдээлэл их бий.
5. Оюутан та дүнгийн үнэлгээтэй сайн танилц W гэсэн үнэлгээ хамгийн муу үнэлгээ. Энэ нь дараагийн уялдаа хичээлээ үзэх боломжийг хаадаг.
6. Оюутан та номын санд сууж номтой нөхөрлө.
7. Та 3 удаа үнэлгээний голч дүн GPA-0,7-оос доош сурвал сургуулиас хасагддаг тул голч үнэлгээгээ өндөр байлга.

Танд ахмад ажилтан зөвлөж байна.

Оюутныг сайн суралцахад эцэг эхийн нийгмийн хариуцлага, үүрэг роль маш их.

1. Эцэг эхчүүд болон асран хамгаалах хүмүүс их, бага ямар нэгэн байдлаар хариуцлага хүлээж байгааг ойлгох хэрэгтэй. Учир нь төлбөр төлнө гэдэг бол маш том хариуцлага. Иймд дээрх хүмүүс төлбөрийг нь төлж байгаа зүйлийнхээ үр дүнг эргэж харж байх ёстой. Иймээс зайлшгүй лхүүхдийнхээ сурлага хүмүүжлийн байдалд хяналт тавих үүрэг үүснэ.

2. Нөгөө талаас хүүхэд эцэг эхийнхээ хөдөлмөрөөр олсон мөнгийг үр дүнтэй зарцуулах хариуцлага хүлээнэ. Энэ утгаараа хичээл номондоо сайн суралцах, сургуулиас зохиогдож байгаа ажилд идэвхтэй оролцох, нийгэмд хувь хүн болон бойжиход анхаарах үүрэгтэй болно.

Дээрхи хоёр үүргийн дундаас болон хичээл чармайлтаас бодит үр дүн гарах ёстой.

Хэрэв хүүхэд нь сайн сурах юм бол эцэг эхэд ямар нэг урамшуулал, бие сэтгэлийн таашаал хүртэх жамтай. Учир нь сайн сурсан оюутан тэтгэлэг, тэтгэмж авдаг болно. Энэ утгаараа эцэг эхийн төлбөр гэсэн хүнд дарамтнаас хөнгөлөгдөнө, хүүхэд сайн сурвал нийгэмд эзлэх байр суурьтай болно. Төгссөн хойноо мэргэжлээрээ амжилттай сайн ажиллах боломж нээгдэнэ гэх мэт таатай нөхцөлүүд бүрдэж эхэлнэ.

Танд ахлах курсийн оюутан зөвлөж байна.

“Өөрийгөө хэрхэн чадваржуулах”вэ?

Оюутан нас гэдэг хүний амьдралын хамгийн оргилуун үе нь байдаг байх. Энэ л үедээ бид ихийг сурч, эзэмшиж, ирээдүйдээ өөрийгөө бэлдэж, хүсэл мөрөөдөлдөө хүрэх чухал алхмаа хийдэг. Ирээдүйд улс орныхоо хөгжил дэвшлийг түүчээлэн авч явах хүмүүс гагцхүү өнөөгийн оюутан залуус та бид билээ. Энэ ч утгаараа бид эзэмшсэн мэргэжилтэй, мэдлэг боловсролтой, зөв төлөвшилтэй хүн болохын төлөө үргэлж хичээх ёстой юм.

Ажил, амьдрал дээр гараад хэр амжилттай байх эсэх нь тухайн хүний мэргэжлийн ур чадвараас гадна бусад хувь хүний мэдлэг, ур чадваруудыг хэр эзэмшсэн эсэхээс ихээхэн хамаардаг. Орчин үед тэдгээр нь ажилд ороход тавигдах шаардлагуудад зүй ёсоор багтах болоод байгаа билээ. Жишээ нь: Харилцааны соёл, зохион байгуулах чадвар, бүтээлч сэтгэлгээ гэх мэт.


Тиймээс оюутан байх үедээ бид дээрх чадваруудыг тодорхой хэмжээгээр эзэмших хэрэгтэй. Үүний тулд аливаа хувь хүний хөгжлийн сургалт, семинар, лекцүүдэд аль болох хамрагдаж, уралдаан

тэмцээнүүдэд идэвхитэй оролцохын зэрэгцээ ямарваа нэгэн клуб, сайн дурын байгууллагуудад явах гэх мэтээр эдгээр чадваруудаа хөгжүүлэх боломжтой. Мэдээж оюутан бидэнд хичээлийнхээ хажуугаар эдгээрт тэр бүр хамрагдах цаг зав хомс, ямар нэгэн үйл ажиллагаа, сургалтын талаарх зарлал, мэдээллийг тогтмол авч чаддаггүй гэх мэтчилэн олон асуудлууд тулгамддаг. Эдгээртэй холбоотой дараах зөвлөмжүүдийг оюутан таньд зориулан хүргэж байна.

1. Шинэлэг зарлал, мэдээллүүдээс хоцрохгүй байх

Аливаа үйл ажиллагааны талаарх зарлал мэдээллийг тус тусын сургуулийнхаа зарын самбарууд, ШУТИС-ийн албан ёсны сайт, группууд дээрээс авах боломжтой. Таньд хэрэгтэй, хувь хүний төлөвшилд тань чухал нөлөө үзүүлэх лекцүүд, уулзалтууд, уралдаан тэмцээнүүдийн болон төрөл бүрийн оюутанд зориулсан арга хэмжээнүүд, сургалтууд, клубүүдийн зарууд их байдаг бөгөөд тэдгээрийг үзэж, сонирхож байх хэрэгтэй.

Аливаа сургууль дээр болох гэж буй үйл ажиллагаануудын талаарх зарыг <http://must.edu.mn/> гэсэн ШУТИС-ийн үндсэн сайтаар ороод дээд хэсэгт байрлах “оюутан” хэсгээс харах



Мөн тус сайтын дээд хэсэгт байрлах үндсэн цэснүүдийн “Оюутан” гэсэн хэсэгт гарч ирэх дэд цэснүүдээс “Зар, мэдээ” гэсэн холбоосоор орж аливаа оюутанд хэрэгтэй зар, мэдээллийг авах.

ШУТИС-ийн оюутнуудын хамгийн олон гишүүнтэй фэйсбүүк группт нэгдэх, мөн тус тусынхаа анги, курс, сургуулийнхаа албан ёсны фэйсбүүк группт нэгдэх,

Мөн сургууль дээрх ОХ, ОЗ-үүд болон Сургалтын албаны зарын самбаруудыг тогтмол үзэж, сонирхож хэвших хэрэгтэй. Учир нь тэнд танд хэрэгтэй болон зайлшгүй чухал зарлал, мэдээллүүд олон байдаг.

Энэ мэтчилэн оюутанд зориулсан аливаа үйл ажиллагаануудын талаарх зарлал, мэдээллүүдийг тогтмол авдаг байх нь тун чухал юм.

2. Клуб, оюутны зөвлөл, оюутны холбоо зэрэгт хамрагдах

Оюутан ахуйдаа клубүүд, оюутны зөвлөлүүд гэх мэт аливаа оюутны нэгдлүүдэд хамрагддаг, үйл ажиллагаанд тогтмол оролцдог байх нь өөрийгөө нээх, хөгжүүлэх олон боломжуудыг бидэнд олгодог.

- Таны сонирхлыг татаж болохуйц зарим клубүүдэд хамрагдах, үйл ажиллагаанд нь тогтмол оролцдог байх нь чухал юм. Жишээ нь: Манай сургуулийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа зарим клубүүдийг доор дурьдвал.

“Empowerment” илтгэл мэтгэлцээний клуб – Өөрийн үзэл бодлоо бусдад зөвөөр илэрхийлэх, ойлгуулах чадварыг эзэмших, мэтгэлцэх болон илтгэх ур чадвараа хөгжүүлэх,

“Соёмбо” клуб их сургуулийн хэмжээнд гэмт хэрэг хэв журмын зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, 5т, 10т-ийн системээр үйл ажиллагаагаа зохион байгуулж, клубийн онцлогоо харуулсан тусгай помбр өмсөж та бидний тав тухтай орчин бүрдүүлэхээр ажилладаг идэвхтэй оюутнуудыг хамруулсан клуб байдаг.

“Багшийн туслах оюутан” клуб –Ерөнхий эрдмийн хичээлүүд математик, физик, хими, дүрслэх геометр зэрэг хичээлүүдийн хоцрогдол арилгахад туслах зорилгоор оюутан багш нар тодорхой хуваарийн дагуу ажилладаг гэх мэтчилэн олон клубүүд байдаг бөгөөд сонирхож байгаа бол эдгээр клубүүдэд нэгдэх боломж нээлтэй байдаг.

Мөн Оюутны зөвлөлд болон Оюутны холбоонд элсэх, орох ОЗ болон ОХ-нд ихэвчлэн өөрийн гэсэн хүсэл эрмэлзэлтэй, зорилготой, өөрийгөө хөгжүүлэх хүсэлтэй олон олон чадварлаг оюутан залуучууд байдаг. Тэдгээрийн нэг болж, тэдэнтэй хамтарч, аливаа үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох, өөрөө санаачлан зохион байгуулах гэх мэтээр нийгмийн идэвхтэй оюутан байх нь өөрийгөө хөгжүүлэх нэгэн том боломжийг бидэнд нээж өгдөг.

Мөн энэ нь ямар нэгэн тэтгэлэгт хөтөлбөрт оролцоход том давуу тал болохын зэрэгцээгээр төгсөөд ажилд ороход ч тэр чухал нөлөөлөх хүчин зүйл болдог билээ. Хамгийн гол нь ингэснээрээ төрөл бүрийн чадваруудыг эзэмшиж, бусадтай харилцаж сурах, багаар ажиллаж сурах гэх мэтчилэнгээр өөрийгөө нээж, хөгжүүлэхэд тань чухал алхам болох болно.

3. Хичээл сурлага, цаг заваа зөв зохицуулах

Өөрийгөө нээх, хөгжүүлэх зорилгоор аливаа сайн дурын болон мэргэжлийн клубүүд, лекц, семинар, сургалтуудад тогтмол хамрагддаг байхын тулд цаг заваа зөв зохион байгуулдаг байх хэрэгтэй.

Хичээл сонголт 2-оо хийхдээ хичээлийн цагаа ихэвчлэн өглөөгүүр байхаар сонгох хэрэгтэй. Учир нь ихэнх үйл ажиллагаанууд өдөр, үдээс хойш зохион байгуулагддаг.

Мөн долоо хоногийн аль нэг өдөр (ялангуяа 5 дахь өдөр) хичээлгүй байхаар сонгох нь их үр дүнтэй байдаг.

Орой бүр маргааш хийх зүйлсүүдийнхээ төлөвлөгөөг ерөнхийд нь гаргадаг байх. Тэдээс тэдийн хооронд хичээлтэй, тэдээс тийм үйл ажиллагаанд оролцоно гэх мэтчилэн.

Тухайн долоо хоногт юм уу ойрын өдрүүдэд болох оролцохыг сонирхож буй үйл ажиллагаануудынхаа хаана болох, хэзээ болох талаар сайтар мэдэж, хичээлийнхээ цаг зав, цонхтой цагуудаараа зохицуулан тэдгээрт оролцох.

Улирлын сүүлийн долоо хоногуудад аливаа оюутанд зориулсан үйл ажиллагаанууд болон бие даалт, сорил, шалгалтуудын үе ихээр идэвхждэг. Энэ үед оюутнууд цаг зав тун бага болдог. Тиймээс хичээлийн ачаалал харьцангуй багатай эхний хэдэн долоо хоногуудад хичээлүүдээ сайн хийж, боломжтой бол урьдчилан судалж, мөн бие даалтуудаа багшаасаа урьдчилан авч хийх хэрэгтэй. Ингэснээрээ ид ачааллын үеэр харьцангуй цаг зав ихтэй байж, аливаа өөрийгөө хөгжүүлэхэд чиглэсэн, сонирхсон зүйлсүүддээ оролцох боломж ихтэй болно гэсэн үг.

Хянасан: СБЗГ-ын дарга, Доктор (Ph.D), дэд профессор Д.Гэрэлт-Од

*Боловсруулсан: ОСҮА-ны ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D), дэд
профессор Д.Цогзолмаа*

ОСҮА-ны мэргэжилтэн Ц.Болдбаатар

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Э.Дэнсмаа

ШУТИС-ийн хэвлэлийн газарт хэвлэв.